

ЖИЖИГ ОРНЫ ТУСГААР ТОГТНОЛЫН АСУУДАЛ: ХХ ЗУУНЫ МОНГОЛЫН ЖИШЭЭН ДЭЭР

*О.Батсайхан**

1911 онд Монгол улс тусгаар тогтнолоо зарласан хэдий ч түүнийг тууштай хүлээн зөвшөөрч, жижигхэн Монголын талд баттай байсан орон тэр үед олон байгаагүй. Иймээс үнэн чанартаа Монголын тусгаар тогтнол, түүний статус тун хэврэг, олон улс гүрнээр баталгаажуулагдах шахам байсан юм.

Гадаад Монгол “булан тохой, хязгаарт ташаалдан, хүчирхэг улсад айл ойрх байдал нь овоолсон өндөг мэт дөрвөн зүг туслах хүнгүй”, “хүчирхэг улсын завсарт хавчигдаж орох эсэх хоёрт бэрх. Хэрэв өөртөө эс тогтновоос гөрөөчинд олзлогдохоос хэлтрэхүйеэ бэрх”¹ хэмээн Богд хаантан Монгол улсын бодит байдлыг тодорхойлсон байна.

Монголын ард түмний үндэсний тусгаар тогтнолоо сэргээх үндсэн эрх ашиг сонирхол Оросоос Монголд эдийн засгийн ашиг сонирхолоо бэхжүүлж, давуу эрх олж авах хэмээсэн бодлоготой давхцаж байсан учраас л 1911, 1921 онуудад Монголын үндэсний хувьсгал үр дүнд хүрсэн хэмээн үзэж байгаа болно.

Монголын төрийн зүтгэлтнүүдийн удаан хугацааны турш явуулсан тэмцэл, нэгэн үзүүрт сэтгэл өвөрлөсөн зорилгынхоо төлөө хийсэн шургуу зүтгэлийн үр дүнд Монголын бие даасан байдал, өөрийн статусыг ямар хэмжээнд байхыг Орос, Хятад хоёрын ашиг сонирхлын огтоллол дээр зөвшөөрүүлж чадсан хэмээн үзсэн юм.

Монголын төрийн зүтгэлтнүүд улсаа улс төр, эдийн засгийн талаар бэхжүүлэх, гадаад улсуудтай холбоо тогтоон үндэснийхээ тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрүүлэхийг чухалчлан үзэж, юуны өмнө энэ чиглэлээр авч хэрэгжүүлсэн эхний алхам нь Орос улстай гэрээ хэлэлцээр байгуулж, хоёр улс харилцан бие биеийг хүлээн зөвшөөрч харилцааны хууль эрх зүйн хэм хэмжээ тогтоох явдал хэмээн үзсэн юм. Үүний үр дүнд 1912 оны 10 дугаар сарын 21 нд Орос улстай хэлэлцээр хийж, Найрамдлын гэрээ байгуулсан явдал² нь Монголын хувьд улс төрийн чухал ач холбогдолтой зүйл байлаа. Эл гэрээгээр Хаант Орос улс Монгол, түүний засгийн газрыг албан ёсоор хүлээн зөвшөөрсөн бөгөөд энэ нь цаашид Монголын тусгаар тогтнолоо бэхжүүлэхэд чухал түлхэц үзүүлсэн алхам болсон юм.

*О.Батсайхан - ОУСХ-ийн тэргүүлэх ажилтан, доктор (Sc.D), профессор

Орос Монголын хооронд Найрамдлын гэрээ байгуулагдсанаас хойш гурав хоногийн дараа Оросын гадаад Яамны сайд Сазанов эл гэрээний талаар Хятадын засгийн газарт мэдээлэхийг үүрэг болгосоны дагуу Оросын элчин Крупенский Хятадын Гадаад явдлын Яамны сайдад 1912 оны 10 дугаар сарын 26 нд уламжлахад, Хятадын Гадаад Яамны сайд «Орос улс Монголын засгийн газрыг хүлээн зөвшөөрчихлөө» шүү дээ «харин Дундад Иргэн улсыг хүлээн зөвшөөрөөгүй л байгаа шүү»³ хэмээн сануулсан байдаг.

Олноо өргөгдсөний Тэргүүн он 12 дугаар сарын 30-нд Монгол Улсын засгийн газраас Чин улсын Дотоод Яам, Засагт тус хийх яам Гадаад хэргийн журганд сахилгаан утас явуулж, Чин улсаас Монголын талаар явуулж ирсэн бодлого монголчуудын “үндсийг таслах, шашныг сөнөөх”-д хүргэж байгаа учраас тусгаар тогтносноо тунхаглан мэдэгджээ.⁴ Монгол улсаас Хаант Оростой 1912 онд гэрээ байгуулсан явдал нь Хятадаас Монголын байдалд хандаж байсан урьдын эзэгнэх хандлагад тодорхой цохилт болж, Хятадын Засгийн газрыг Орос улстай Монголын асуудлаар хэлэлцээ хийхэд хүргэжээ. Орос, Хятадын хооронд гэрээ байгуулах асуудал удтал сунжирснаас болж, 1913 оны 10 сарын 23 нд «Гадаад Монголын автономийг хүлээн зөвшөөрөх тухай Орос, Хятадын тунхаг»⁵ нэртэй товч тунхаг гаргаж, түүндээ цаашид баримтлах бодлогын ерөнхий чиглэлийг тохиролцсон билээ. Энэ тохиролцоо нь хоёр тал Монголын асуудлаар харилцан буулт хийсний үр дүн болсон юм. Иймээс эл баримт бичгийн талаар Монгол улсын засгийн газар 1913 оны 12 дугаар сарын 5-нд Хүрээнд суугаа Оросын төлөөлөгчид нот илгээж, Орос хятадын тунхагийг хууль бус хэмээн эсэргүүцлээ илэрхийлсэн байдаг. 1912 оны Орос, Монголын Найрамдлын гэрээ, Орос Хятадын 1913 оны тунхаг, нотууд байгуулсан явдал нь Монголын тусгаар тогтнолын асуудлыг гурван улсын хэлэлцээрээр авч үзэх үндэслэл болсон юм.

1914 – 1915 онд Хаант Орос, Дундад Иргэн хоёр гүрэн тусгаар тогтнолоо дөнгөж сэргээн тунхаглаад байсан Монголын төлөөлөгчдийг арга буюу оролцуулан Хиагтад гурван этгээдийн хэлэлцээр хийсэн нь ХХ зууны эхэн үеийн олон улсын харилцаанд гарсан ховор тохиолдол юм. Учир нь тухайн үеийн олон улсын практикаас үзэх аваас, жижиг орнууд өөрийн үндэсний тусгаар тогтнол, бие даасан байдлын төлөө, өөрийн эрх ашгийг хамгаалахын төлөө тэмцэх боломжоор хангагдаж чадахгүй байсан үе юм. Энд би Болгарын асуудлыг шийдсэн 1878 оны Орос, Туркийн Берлингийн трактат

гэрээний тухай хэлэх байна. Хойд Болгар автономит улс байх эрх олсон боловч өөрөө энэхүү гэрээ хэлэлцээрт оролцоогүй билээ. Харин Монгол улс өөрийн бие даасан байдлын төлөө тэмцэх боломжыг олж Гурван улсын гэрээнд оролцсон юм.

Хиагтын гурван улсын гэрээгээр Орос, Хятад хоёр их гүрэн өөрсдийн эрх ашиг, хэлэлцэгч гурван этгээдийн тус тусын сонирхолд ямар нэгэн хэмжээгээр нийцсэн байдлаар Монголын оршин тогтнох хэлбэр хийгээд дотоод, гадаад эрхийн хэм хэмжээг тогтоосноор Монгол улсын олон улсын статус тодорхойлогджээ. Энэ нь нэг талаас хүчирхэг нь буурайгаа дарлах, өөрийн эрх ашигт захируулсан зүйл болсон хэмээн хэлж болох боловч нөгөө талаас нь авч үзвэл хоёр хүчирхэг улсын Монгол дахь ашиг сонирхлын огтолцол дээр Монголын тал өөрийгөө хамгаалан үлдэх, Монголыг нэг улсын доторх бус олон улсын субъектын түвшинд хүргэх хэтийн төлөв бүхий алхам хийснээр өвөрмөц онцлогтой болсон юм.

Гурван улсын хэлэлцээрт оролцохдоо Монгол улсын засгийн газар, түүний бүрэн эрхт төлөөлөгчдийн тавьсан зорилго юунд оршиж байв хэмээн үзвээс,

- 1911 онд тунхагласан Монгол улсынхаа тусгаар тогтнолоо баталгаажуулах,

- Монголын Засгийн газрыг дэмжиж, нэгдэхээ илэрхийлсэн Өвөр Монгол, Баргын монголчуудыг өөртөө хамааруулж авах зорилго тавьсан байна.

- Гурван улсын хэлэлцээрт оролцохдоо Монголын талын өмнөө тавьсан зорилт хэрэгжсэн байдал:

Эл гэрээгээр Хятадын сюзеренитет бүхий өөртөө зэрхсэн Монгол нь:

- Эзэн хаантай
- үндэсний Засгийн газартай
- дотоодын бүх асуудлаа бие даан шийдэх эрхтэй
- өөрийн нутаг дэвсгэртэй
- тодорхойлон тогтоосон улсын хил хязгаартай
- өөрийн үндэсний цэрэгтэй
- өөрийн нутагт Орос, Хятадын аль алины төлөөлөгчийн газрыг хамгаалахаас илүү цэрэг оруулахгүй байх
- хятад иргэдийг олноор оруулахгүй байх,
- худалдаа үйлдвэрийн салбарт олон улсын гэрээ хэлэлцээр байгуулах онц эрхтэй болсон юм.

- Монголын эдгээр эрхээ хэрэгжүүлэхэд нь Орос, Хятадаас оролцохгүй байхаар тогтоосон юм.
- Харин улс төрийн салбарт хязгаарлагдсан эрхтэй улсын шинжтэй тогтоосон боловч гэрээний монгол эхэд «улс» гэдэг үгийг хэрэглэхийг Монголын төлөөлөгчдийн шургуу тэмшлийн хүчинд зөвшөөрсөн билээ. Дээр нь Гурван улсын гэрээний дүнгийн талаар Оросын Гадаад Яамны сайд Оросын төрийн думын хурал дээр ярихдаа: Монголчууд улс төрийн талаар ч гадаадын улс оронтой гэрээ хэлэлцээр хийхийг үгүйсгэхгүй юм⁶ гэсэн байгаа. Энэ хуралд Японоос Орост сууж байсан элчин сайд Мотоно оролцсон байдаг.

1915 оны гурван улсын Хиагтын гэрээгээр Монгол улс 1911 онд тунхаглан зарласан тусгаар тогтнол, бие даасан байдлаа хязгаарлуулсан ч хоёр хөршөөрөө эвдүүлэхгүй байх олон улсын эрх зүйн баталгааг буй болгосон юм.

Монголын засгийн эрх баригчид Хиагтын хэлэлцээгээр өөрийн тусгаар тогтнол, бие даасан байдлыг баталгаажуулахыг зорихдоо Монгол улс уулаасаа Хятадаас тусдаа оршин тогтнож байсан түүхэн уламжлалаа урьтал болгохын хамт 1911 онд Хятадаас өмнө Манж чин улсаас салж, тусгаар тогтнолоо тунхагласан явдлыг үндэслэл болгосон юм. Эл гурван улсын Хиагтын гэрээ Монгол улсыг ар, өвөр болгон хувааж, газар нутгийн хувьд Өвөр Монголыг Монгол улсын гал голомтоос нь хуульчлан тусгаарласан эрх зүйн баримт болсон юм. Чингиснээр Монголынхоо тусгаар тогтнолын төлөө монгол овогтоны нэг хүчээр тэмцсэн нэгдмэл эрмэлзлэл, зорилгоо биелүүлэхэд нь 1915 оны гэрээ хориг тавьж, улмаар монгол овогтон саланги тусгаар байх нэгэн нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Гурван улсын хэлэлцээрт оролцсон Хятад улсын засгийн газар, түүний бүрэн эрхт төлөөлөгчдийн зорилго юунд оршиж байв хэмээн үзвээс,

- Хятад улс Ар, Өвөр Монголыг бүрэлдхүүндээ багтаасан Манж Чин улсыг залгамжлагч гэж өөрийгөө үзэж, монгол үндэстний талаарх бүх эрхийг өвлөн авч хадгалах,

- Үүний тулд Орос Хятадын Тунхаг бичгийг Монголын талаар зөвшөөрүүлэх, Монголын тусгаар тогтнол гэдгийг хүчингүйд тооцох, Олноо өргөгдсөн оны цолыг хүчингүй болгох, Монгол улсын хааны цолыг хэрэгсэхгүй болгох зорилго тавьсан байна.

- Гурван улсын хэлэлцээрт оролцоходоо Хятадын тал Өвөр Монголын хувьд зорьсондоо хүрсэн юм. Харин Ар Монголын хувьд Монгол, Оросын төлөөлөгчдийн эсэргүүцэлтэй тулгарч, Ар Монголд нэр төдий сюзеренитет эрхтэй үлдсэн юм.

Гурван улсын хэлэлцээрт оролцсон Орос улсын засгийн газар, түүний бүрэн эрхт төлөөлөгчдийн зорилго юунд оршиж байв хэмээн үзвээс,

- 1911 оны Монголын үндэсний хувьсгалд тусалснаараа Ар Монголд олж авсан улс төр, эдийн засгийн байр сууриа баталгаажуулах, Ар Монголыг өөрийн нөлөөний эрхшээл голлосон газар болгохыг зорьсон юм. Орос улс өөрийн дэлхийн өөр өнцөгт алдсан эрхээ Монголд нөхөж олж авах,

Гурван улсын хэлэлцээрт оролцоходоо Оросын талын өмнөө тавьсан зорилт хэрэгжсэн байдал:

- Хиагтын хэлэлцээрийн эхний үеэр Хиагтад Оросын Засгийн газраас шаардсанаар Орос-Монголын төлөөлөгчдийн хооронд нууцаар мөнгө зээлдүүлэх, буу зэвсгийн, төмөр зам байгуулах, цахилгаан мэдээ байгуулах тухай дөрвөн зүйлийн гэрээ⁷ байгуулсан явдал бол Монголд олж авсан улс төр, эдийн засгийн байр сууриа бататгаж авсан хэрэг юм.

- Ар Монголд Хятадын сюзеренитет эрхийг ёс төдий тогтоосноор Орос улс дэлхийн нэгдүгээр дайн нэгэнт эхэлсэн нөхцөлд Хятад улстай харилцаагаа харилцан ойлголцох үндсэн дээр хэвийн болгохыг сонирхсоноос гадна өөрийн холбоотон Англи, Франц улсуудын Хятадын талаарх байр суурьтай зөрчилдөхгүй байхыг хичээжээ. Энэ нь Их гүрний бодлогын илрэл байсан.

Хаант Орос улс Монголын тусгаар тогтнолыг дэмжсэн бусад монгол үндэстэний талаарх Монголын байр суурийн эсрэг байсан нь Японтой байгуулсан 1907, 1910, 1912 онуудын гэрээгээр Монголыг нөлөөний хүрээ болгосон тохиролцоогоо баримталсан, Хятадтай байгуулсан гэрээгээр Баргыг өөрийн нөлөөний онцгой орон хэмээн тохиролцсонтой холбоотой байв. Мөн Оросын доторх буриад зэрэг монгол овогтонууд монголын үндэсний хөдөлгөөнтэй нийлэхээс болгоомжилсонтой холбоотой байв. Ер нь Монгол үндэстний нэгдэхээс айж байсан, үүний тод илрэл 1912 онд Оросын Гадаад яамны сайдаас Дундад Иргэн улсын Засгийн газарт явуулсан цахилгаанд өгүүлэхдээ Монгол үндэстний хөдөлгөөн өргөжин тэлж манай буриаддуудтай нэгдэх аваас манайд төдийгүй танайд ч мөн адил аюултай. Иймээс монгол

овогтоны нэгдэх хөдөлгөөнөөс болгоомжлох хэрэгтэй гэсэн санаа илэрхийлсэн байдаг.

Хиагтын хэлэлцээрт Өөртөө эзэрхсэн Монголын нутаг дэвсгэрийг «урьдах Хүрээний сайд, Улиастайн жанжин, Ховдын сайдын захиргаанд байсан газрууд бөгөөд Дундад Иргэн улс лугаа нийлсэн хил болбоос Зүүн зүг Хөлөн буйрын хязгаар, Өмнө зүг Дотоод Монгол, Баруун өмнө зүг Шинэ хязгаар, Баруун зүг Алтайн хязгаар лугаа зах нийлсэн халхын 4 аймаг ба Ховдын хязгаарын олон хошуудын хилээр баймой»⁸ хэмээн зааглан тогтоосон нь Хятадаас туурга тусгаар олон улсын эрх зүйн субъект мөнийг хүлээн зөвшөөрсний тод нотолгоо мөн. Хил хязгаарын талаарх энэ заалт нь хожим 1945 оны гурван гүрний Ялтын хурлаар Монгол улсын статус-кво тогтооход үндэслэл болж өгсөнөөс гадна хөрш гүрнүүдтэй хилийн маргааныг шийдвэрлэх, хилийг нарийвчлан тогтооход баримтлал болсон билээ.

Оросын Монголын талаар баримталж байсан бодлого нь 1907-1910, 1912 оны Орос-Японы алс дорнод дах нөлөөллийн бүс хуваах тухай нууц хэлэлцээрүүдийн агуулгаар тодорхойлогдож байлаа. 1911 оны 8 дугаар сарын 2-нд А.А.Нератов В.Н.Коковцевт хандан: "Алс дорнодахины манай бодлогын үндэс нь Японтой байгуулсан хэд хэдэн хэлэлцээр болон Манжуурт дахь бий болсон үйл ажиллагааны нийтлэг нөхцөл байдалаас үүдэлтэй юм. Алс Дорнод дахь энэхүү амгалан тайван, аюулгүй байдлын гол хүчин зүйлийг эрсдэлд оруулах нь болчимгүй хэрэг болох буй за"⁹ хэмээн бичсэн байдаг. 1912 онд Монголтой Найрамдлын хэлэлцээр байгуулахдаа ч, 1913 онд Орос-Хятадын тунхаглалд гарын үсэг зурахдаа ч, 1915 оны Гурван этгээдийн Хиагтын хэлэлцээрийн туршид ч Оросын засгийн газар дээрх Японтой байгуулсан хэлэлцээртээ үнэнч байж, байр сууриа тууштай баримталж байв.

Энэ зааг үед Орос орон Монголын талаар ямар бодлого баримтлахаас 1911 оны Монголын үндэсний хувьсгалын үр дүн, Зөвлөлт Орос улс Монголын талаар ямар чиглэлтэй байхаас Монголын тусгаар тогтнолын асуудал, цаашилбал ХХ зууны Монголчуудын хувь заяа хамаарч байсан нь үнэн түүх билээ. Хаант Орос улс Богд хаант Монгол улс хоёр хоорондоо Гэрээ байгуулж, баримт бичгүүд солилцсоноор Монголд эзлэх Хаант Оросын нөлөө ихсэх болсон нь Орос, Дундад Иргэн улсын хүчний харьцаанд урьд байснаас нилээд өөрчлөлт орж, улмаар хоёр тал монголын асуудлаар хэлэлцээр хийх хэмжээний асуудал болсон байна. Энэ нь Хятадууд

монголыг урьдын адил дангаар эзэрхэх гэсэн хятадын байр сууринаас хальж, Монголын асуудлыг Оростой ярилцах болсон нь монголчуудын хувьд багагүй дэвшил болсон хэмээн үзүүштэй. Нөгөө талаар Орос Монголыг хэлэлцээр хийх эрх бүхий этгээд хэмээн үзсэн нь Монгол өөрийн тусгаар тогтнолын төлөө асуудалдаа өөрийн саналаа оруулж, түүнийхээ төлөө тэмцэх боломжоор хангагдаж эхэлсэн ололт байлаа. Энэ бол Богд Хаант Монгол улсын төрийн удирдагчдын асар их ухаан, хүчин чармайлтын үр дүн хэмээн үзмээр санагдана.

Мөн 1913 оны 11 дүгээр сард Ерөнхий сайд Сайн ноён хан Намнансүрэн тэргүүтэй Богд хаант Монголын улсын төлөөлөгчид Орос улсад айлчлах үеэр Оросын тал Орос, Думдад улсын хооронд Монголын асуудлаар байгуулсан тунхагийн заалтуудыг танилцуулсан байдаг ба Сайн ноён хан Намнансүрэн нар эл тунхагийг хүлээж авахаас эрс татгалзсан хариу өгч байжээ. Түүнчлэн Намнансүрэн нар Петербургт байх хугацаандаа Олноо Өргөгдсөний 3 дугаар оны өвлийн дунд сарын 18-наас өвлийн сүүл сарын 11-ний хооронд Орос улсын Гадаад хэргийн яам, Петербургт суугаа Дундад, Англи, Америк, Япон, Турк зэрэг 10 улсын элчин сайдад нот явуулж, Орос, Хятадын 1913 оны тунхагийн талаарх өөрийн засгийн газрын байр суурийг “манай Монгол улс Хятадын холбогдлоос бүрмөсөн салсан учраас Монгол улсын зөвшөөрөөгүй байхад тогтоосон ямар ч холбоог огт хүлээхгүй Иймд Монгол, Хятадын харилцааны асуудлыг гагцхүү Монгол улс өөрөө шийдэх ёстой” гээд Дундад улстай “айл улсын энх түвшний ёсоор харилцан найрамдахыг бодож” буй хэмээн тодорхойлж байжээ.¹⁰

1915 онд байгуулсан Хиагтын гурван этгээдийн гэрээгээр баталгаажсан Оросын байр суурь нь XX зууны туршид Монголын талаар Оросоос баримталж явуулах бодлогоо тодорхойлсон хэрэг байлаа.

1917 онд Орос оронд Октябрийн хувьсгал ялж, тус орны нийгмийн баримжаа өөрчлөгдсөн хэмээн бид тунхаглан яривч, үнэн хэрэг дээрээ Орос орон, түүний удирдлага, социализмын тухай онолыг хэрэгжүүлэгч -Ленин, Сталин тэргүүтнүүд их гүрний байр суурь, бодлогоос ухарч чадаагүй юм. Харин ч зарим талаар улам өргөжүүлсэн байж магадгүй. 1915 онд байгуулсан Хиагтын хэлэлцээр ёсоор Орос орны эдийн засгийн асар их ашиг сонирхол Монголд бий болж, нөгөө талаас хятадууд өөрсдийн нэгэнт бий болгосон байр сууриа тийм ч амархан алдахгүйг хичээж байсан юм. Ийм нөхцөлд Монголд 1921 оны үндэсний ардчилсан хувьсгал өрнөж, Зөвлөлт Орос улс цэргийн

хүчээр тусламж үзүүлэв. Монголын үндэсний тусгаар тогтнолд Хятадын зүгээс бодитой аюул занал учирч байсан тул энэхүү тусламж Монголд их үүрэгтэй байсаныг онцлон тэмдэглэх учиртай. 1911 онд эхэлсэн Монголын үндэсний хувьсгал 1915 оны Хиагтын гэрээгээр Ар Монголоор хязгаарлагдах болж, улмаар 1921 онд Ар Монголын үндэсний ардчилсан хувьсгал болж бэхжсэн юм. Эл хувьсгалаар монголчууд хэдэн арван жил тэмцэж ирсэн тусгаар тогтнолоо сэргээж чадсан билээ.

1924 оны 5 дугаар сарын 31-нд ЗХУ, Хятад улс хоёрын хоорондын асуудлуудыг зохицуулах ерөнхий зарчмуудын тухай гэрээ байгуулж түүнийхээ тавдугаар зүйлд: гадаад Монгол бол Дундад иргэн улсын нэгэн хэсэг газар гэдгийг ЗХУ хүлээн зөвшөөрч тэндэх хятадын бүрэн эрхт байдлыг хүндэтгэнэ хэмээн заажээ. Энэ нь 1913, 1915 онуудад хоёр их гүрний хооронд байгуулсан хэлэлцээрийг хэвээр мөрдөж байгаа гэдгийг дахин нотолсон хэрэг болохоос бус Хаант Орос Зөвлөлүүдийн Бүгд найрамдах улс болсноор нь бодлогоо өөрчилсөн зүйл байхгүй болохыг илтгэн харуулсан хэрэг.

Өнгөрсөн түүхээ эргэн харах аваас 1910-аад онуудад тодорхойлсон Монголын талаарх Орос-Их гүрний бодлого бараг зууны турш хэрэгжихдээ замдаа таарсан элдэв саад, тогтор, бэрхшээл, эерэг, сөрөг бүгдийг зөвхөн өөрийн эрх, ашиг сонирхолд захируулан нухчин дарж, их гүрний эрх ашгаа ямагт тэргүүн зэрэгт баримтлаж байжээ. Энэ бол монголчуудын хувьд хүлцэн тэвчихээс өөр аргагүй зүйл байв. Өөрөөр хэлбэл, Хятад Монголыг бүхлээр нь залгихыг хүсэж байсан учраас үндэсний тусгаар тогтнолоо авч гарах үүнээс илүү арга бид олж чадаагүй болохыг түүх нэгэнтээ нотлож буй.

Монголчууд аливаа нэгэн их гүрний нөлөөнд автаж, түүгээр тусгаар тогтнол үндэсний өнгө төрхөө бүрнээ тодорхойлуулахыг тэд хүсдэггүй байсан юм. Энэ байдал Хиагтын 1915 оны гэрээний дараа Шударга баатар гүн Бавуужав нар автономыг үл зөвшөөрөн, Японы эзэн хаанд тусламж хүссэн бичиг илгээсэн (энэ тухай Магсар хурцын бичсэн Монгол улсын шинэ түүх номонд тодорхой бий), 1921 оны үндэсний ардчилсан хувьсгалын үеэр Богд хаан Жалханз хутагт Дамдинбазар нарын АНУ-аас, шадар Цэцэн ван нарын Японоос, Ардын намынхны Зөвлөлт Оросоос тусламж эрсэн бичгүүдэд тамга дарж зөвшөөрлийг өгсөн¹¹ зэргээр илэрч байсан юм. Мөн 1922 оны 11-дүгээр сарын 16-наар өдөрлөж “Монголын олон аймаг шавийг баригч Ачит номун дүйнхор Манзшири хутагтын” батлан үсэг зурсан

Жибин (Япон) улсын эзэн хаанд явуулсан Цэрэнпил гүнгийн бичгийг энд дурьдаж болох юм. Уг бичигт: “ойр дахинаар баярлалдах, хол дахинаар сүсэглэлдэх гэгээн гэрэлт их засгийн хишгийг батад тогтоохыг”¹² хүсэж буйгаа илэрхийлсэн байдаг.

Харин 1924 оны дээрх гэрээнд зөвлөлтийн талаас гарын үсэг зурсан н.Карахан хятадын “Ишибао” хэмээх сонины сурвалжлагчтай ярилцахдаа: “Монголд өөрийн засаглал тогтоох эрх олгох нь монгол хятадын харилцааны асуудлыг бүх талаар үндсэнд нь шийдвэрлэх зөв арга болно гэж тэмдэглэж байна.”¹³ Харин 1924 оны 6 дугаар сарын 25-ны “Ардын эрх” сонинд “Орос хятад хоёр улсын гэрээ тогтоосон тухай” өгүүлэл хэвлэгдэн гарч: “Монголын ард түмэн дундад улсын харгис засгийн дахин дарлан бурангуйлахыг тэсвэрлэхгүй...хэзээд эсэргүүцэн тэмцэх болно”¹⁴ гэсэн утгатай зүйлс бичигдсэн байна.

Дорнод-хятадын төмөр замыг хятадууд булаан авч, энд буй болсон будлиант байдал Монголын эдийн засагт тодорхой (Монголын импортын 43.5, экспортын 22 хувийг эзэлж байжээ) үлэмж хувийг эзэлж байсан Хятадыг хаахад хүргэв. Бээжин 1929 оны 7 сард БНМАУ-ыг эдийн засгийн талаар хяхах болсоноо албан ёсоор зарлав. 1929 оны 11-дүгээр сард Хятад монголын хилийг нээх, худалдааны харилцааг сэргээх саналыг Монголын засгийн газраас Зөвлөлтийн засгийн газарт тавьсан байна. Энэ талаар Зөвлөлтийн бүрэн эрхт төлөөлөгч А.Охтин “Монголын зах зээлийг будлианы өмнөх шиг Хятадын эрхшээлд булаан оруулах хэрэгцээгүй” хэмээн үзэж байжээ. Энэ үеэс хойш Монголын эдийн засаг, улс төр Зөвлөлт Орос улсаас дангаараа хамаарах болсон билээ.

Монгол улс бол “СССР, Хятад хоёр улсаас баталсан бөгөөд бусад олон улсаас зөвшөөрөн хүлээсэн төвийг сахих улс болох хэрэгтэй. Энэ нь үлгэрлэвээс Швейцари улс лугаа адил болой” хэмээн “баруунтны гол онолч” гэж буруушаагдан байсан Ж.Цэвээн бичсэн бий. Ийнхүү төвийг сахих бодлого явуулах нь Монголын улс төр, нийгэм, эдийн засгийн хувьд ихээхэн ач тустай байсан байж болохыг өнгөрсөн түүх нотлон харуулав. Монголын баруунтнууд Зөвлөлт, Хятадыг ялгалгүй айлчилж, Англи, Франц, Японтой түнш бололцохыг эрхэмлэж байжээ. 1926 оны 9-дугаар сарын 15-нд “Энэ удаа Япон улсын сургуульд сурагч нарыг явуулахыг түдгэлзүүлэн уг явуулахаар томилогдсон нэр агчдыг Герман улсын сургуульд нэмэн одуулахад Нацагдорж, Пагмадулам, Санж, Пунцаг, Лувсандулам, Лувсанчүлтэм нарыг томилсон” тухай НТХ-ны бичиг ч үүнийг тод жишээ даруй мөн.

Хувьсгалын эхний жилүүдэд монголын нам төрийн удирдагчид “Монголын Ардын Намаас өөрийн үзэл явлыг бүх Монгол дор дэлгэрүүлж эцэс дор бүгдээр нэгдэхийг эрмэлзэх тул Орос император хааны үест Монголоос эзэрхэн тасалж авсан Танну-Урианхайг эгүүлэн өгч нөгөөтэйгүүр бүх Монгол нэгдэж улс болохуй дор Зөвлөлт засгийн газраас ямар бодлоготой буйг манай дор мэдэгдэхийг хүсэхээс гадна Монгол нь орос, хятадын зөвшөөрлийг харгалзах үгүй эрхтэй болохыг хүсмой” хэмээсэн бодлого явуулж, асуудал тавьж байжээ. Ийнхүү Танну-Тувагийн асуудал гарч ирсэн бөгөөд 1924 онд Монголоос Танну Тувад явуулсан төлөөлөгч, сургагч нарт олгох зааврыг Намын Төв Хорооны тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцэхэд Дамбадорж, Цэрэндорж, Цэвээн нараас ийнхүү өгүүлж байжээ. Тэд: Танну Урианхай тусгай улс болох гэх буюу түүнийг манай нам засгаар зөвшөөрүүлэх хэмээх нь хүүхдийн тоглоом мэт хэрэг болох ба мөн нэгэнтэйгүүр бусдын дарлагдлаас салж үндэс угсаа, шашин шүтлэг заншлага, суртлаа дагаж тус Монгол улстайгаа нийлэн нэгдэж нэгэн гэр улс болон улс төрөө мандуулахыг хүссэн Танну-Урианхайн олон түмэн ардын чин зорилгоос илэрхийлэгдэн гарсан хүсэл эрмэлзээг хүчээр хаалгалан боогдуулж та нар заавал тусгаар болсугай хэмээн зөвшөөрүүлэх нь үнэхээрийн эргэлзээтэй бөгөөд татгалзалтай хэрэг¹⁵ хэмээн эсэргүүцэж байжээ. Гэвч тэдний эсэргүүцэл талаар өнгөрч Танну-Туваг улс болгон “Коминтерний зорилго зааврыг дагаж” хүмүүсээр зөвшөөрүүлж баталжээ. Ийнхүү батлах үест хүчин мөхөсдсөн Амар, Жадамба нараас “Ер чингэж тусгаар улс болгох нь амархан хялбархан хэрэг болжуху” хэмээн өгүүлж суужээ.

Дамбадорж, Цэвээн Жамсранов нарын энэ талаар баримталж байсан бодлого Коминтерний зарим нөхдөд таашаагдаагүй бөгөөд иймээс ч Коминтерний зүгээс “Монгол овогтныг албадан нэгтгэхийг зорих явдлыг эсэргүүцэх” хэрэгтэй гэсэн заавар тэдэнд удаа дараа ирж байсан юм.

Сталин ба Монголын статус-кво

1932 оноос хойш бараг жил дараалан Сталин тэргүүтэй Зөвлөлтийн удирдагчид Монголын удирдагчдыг хүлээн авч, одоо юу хийх ёстойг нарийн зааварлах болов. 1933 оны 12 дугаар сард Довчин, Элдэв-Очир нарын Монголын нам, засгийн төлөөлөгчдийг хүлээн авч уулзахдаа, Сталин: лам нарыг “улс доторх улс байна” хэмээн дүгнээд, найдвартай хүмүүсийг дотор нь оруулж дотроос нь бутаргах

хэрэгтэй хэмээн зааварчилжээ. Танай засгийн газар, намын удирдлага дээрээ нэгдмэл, нам засгийн тэргүүлэгчид нэг байх ёстой. Харин тэрнээс дооши удирдлага төрийн болон намын гэж зааглагдсан байх хэрэгтэй гэжээ. Сталин мөн Монголын армийн тухай сонирхож: арми 8000 хүнтэй, 20 орчим хөнгөн танкеттай, арваад нисэх онгоцтойг мэдээд Ворошиловт хандан: эдэнд армия бэхжүүлэхэд нь туслах хэрэгтэй байна хэмээн хэлж байжээ.

1934 онд Монголын удирдагч нартай уулзахдаа Сталин БНМАУ-ын тусгаар тогтнолын асуудлаар ярихдаа: Та нар эхлээд Хятадаас тусгаар болох хэрэгтэй, дараа нь бусад улсаар хүлээн зөвшөөрүүлж болно, тэр цагт та нар барга болон цахарын хувьд татах хүч болж чадна гэсэн зүйлсийг хэлжээ. Энэ юу хэмээсэн үг байв. Үүнийг тухайн үеийн удирдагчид, сүүлийн судлаачид ч тэр бүр анзаарахгүй шахам явж иржээ. Сталины энэ үг бол Монголын талаарх Хятад-Оросын урьдын тохироо, тухайлбал 1915 оны Гурван этгээдийн хэлэлцээр, 1924 оны Орос-хятадын гэрээний 5 дугаар зүйл хүчинтэй хэвээр байгаа болохыг сануулсан хэрэг байлаа.

Гэндэн тэргүүтэй Монголын төлөөлөгчид Сталинтай дахин 1934 оны 11 сарын 27-нд уулзсан байна. Чингэхэд Сталин Монголын батлан хамгаалах асуудалд онцгой анхаарал тавьж, монголын цэргийн тоог 12 000 -д хүргэх, зөвлөлтийн тал 5 жилийн турш жил бүр 6 сая төгрөг армийн зардалд нөхвөр болгон буцалтгүй өгч байхаар амалсан байна. Энэ уулзалтаар ЗХУ ба БНМАУ-ын хооронд харилцан үл довтолох тухай гэрээ байгуулах саналыг Сталин тавьж, улмаар энэ нь “Цэргийн довтолгооныг урьдчилан зайлуулах, түүнээс урьдчилан сэргийлэх хэрэгт бие биеэ бүх талаар харилцан дэмжинэ. Ямар нэг гуравдахь этгээд ЗСБНХУ, БНМАУ-ын аль нэг рүү довтолбол бие биедээ тусламж дэмжлэг үзүүлнэ” хэмээсэн агуулга бүхий аман хэлэлцээр байгуулсан тухай түүхэнд тэмдэглэгджээ.

1935 оны 12-дугаар сарын 30, 1936 оны 1-дүгээр сарын 7-нд П.Гэндэн тэргүүтэй Монголын засгийн газрын төлөөлөгчид Москвад ээлжит айлчлалаа хийж энэ өдрүүдэд Сталин лугаа уулзжээ. Энэ уулзалтаар Гэндэнг: Урьд уулзалтаар хэлсэн зүйлсийг биелүүлсэнгүй, тухайлбал батлан хамгаалах асуудалд бага анхаарч байна хэмээн зэмлээд, “Зөвлөлт улс биднийг хуурч Монголоос ашиг хонжоо хайж байна, иймд япончуудтай нөхөрлөх нь зүйтэй гэж үзэж байгаа бол түүгээрээ бол” хэмээн Сталин Гэндэнг буруутгажээ. Түүнчлэн лам нартайгаа тэмцэхгүй байна хэмээн буруушаажээ.

Сталин АНУ-ын хэвлэлийн томоохон агентлагийн ерөнхийлөгч Скриппс-Ховард лугаа 1936 оны 3-дугаар сарын 1 нд хийсэн ярилцлагадаа: “Хэрэв Япон нь БНМАУ-ын тусгаар тогтнолд халдан довтлох аваас бид БНМАУ-д 1921 онд тусалсаны нэгэн адил туслана” хэмээн илэн далангүй мэдэгдсэн байдаг. Энэхүү ярилцлагаас хойш тун удалгүй Улаанбаатар хотноо 1936 оны 3-дугаар сарын 12-нд Зөвлөлт-Монголын харилцан туслалцах протокол гэрээ байгуулагджээ. 1934 оны аман хэлэлцээрийг баталсан уг гэрээнд хоёр этгээд нь хэрэв ямар нэгэн 3 дах этгээдийн зүгээс ЗСБНХУ буюу БНМАУ-ын нутаг дэвсгэрт довтлох аюул тохиолдвол бие биедээ тусламж, түүний дотор цэргийн тусламж үзүүлэх явдлыг харилцан үүрэг болгон авч байна хэмээн заажээ. Зөвлөлт-Монголын хооронд харилцан туслалцах протокол гэрээ байгуулсантай холбогдуулан Хятадын засгийн газраас ЗСБНХУ-ын Засгийн газарт “Гадаад Монгол бол Бүгд Найрамдах Хятад улсын салшгүй хэсэг мөн учир гадаадын ямар ч улс түүнтэй ямар нэгэн хэлэлцээр байгуулж үл болно” гэсэн эсэргүүцэл илэрхийлжээ. Үүний хариуд ЗСБНХУ-ын ГХАК-аас Хятадын хэргийг түр хамрагчид өгсөн нот бичигт: “Протокол байгуулснаар СССР ба Хятад, СССР ба БНМАУ-ын хооронд өнөө хүртэл тогтож ирсэн албан ёсны ба бодит харилцаанд ямар ч өөрчлөлт оруулаагүй болно. СССР нь харилцан туслалцах протокол байгуулахдаа 1924 онд Бээжинд гарын үсэг зурсан зөвлөлт-хятадын хэлэлцээр огтхон ч үл хөндөгдөн хүчин төгөлдөр хэвээр байна гэдгээс үндэслэсэн юм. ЗСБНХУ-ын хувьд энэ хэлэлцээр цаашид ч хүчинтэй байна гэдгийг дашрамд Зөвлөлт засгийн газар дахин нотолж байна” гэж мэдэгдсэн байна.

Энэ бол ЗХУ их гүрэн байсанаа, мөн их гүрнүүдийн хоорондын тохиролцоо хэвээр болохоо илэрхийлсэн хэрэг юм. Бодитойгоор оршин буй Монголын тусгаар тогтнолыг Хятад хүлээн зөвшөөрч чадахгүй байсан хэрэг.

1937 онд Амар тэргүүтэй Монголын Засгийн газрын төлөөлөгчид, 1938, 1939, 1940 онд Х.Чойбалсан нарын Монголын Засгийн төлөөлөгчид Москвад удаа дараалан айлчилж, Сталинаас удаа дараагийнхаа зөвлөгөөг авсаар байлаа. Олон улсын нөхцөл байдал өөрөөр эргэж, Дэлхийн 2 дугаар дайн гарч төгсгөлд нь гурван их гүрнүүдийн тэргүүн нарын 1945 оны Ялтын уулзалтаар “БНМАУ-ын статусвог одоогийн байгаа хилээр нь хүлээн зөвшөөрөхөөр” тохиролцсон нь Монголчуудын тусгаар тогтнол бас дахин бэхжих үүд хаалга нээгдсэн юм.

Сталин “хэрэв бид Гадаад Монголыг хамгаалах ямар нэгэн хууль эрхийн үүрэг байгаагүй бол Алс Дорнодоо тэр чигээр нь Японд алдаж гүйцэх байсан... Бид өөрийн Алс Дорнод дахь газар нутгийг хамгаалахын тулд Гадаад Монголд Хуулийн эрх олж авах ёстой юм” хэмээн дээрх алхамаа тайлбарласан байдаг. Мөн Сталин: “Гадаад монголчууд Хятадтай ч тэр, ЗХУ-тай ч тэр нэгдэхийг хүсэхгүй. Тэд тусгаар тогтнохыг л хүсэж байгаа. Хятадын хувьд Гадаад Монголыг тусгаар болгох нь илүү ашигтай, Хэрэв тэгэхгүй бол Гадаад Монгол бүх монголчуудыг татан нэгтгэх аюултай. Ингэж Дотоод, Гадаад Монгол нэгдвэл Хятадад ч мөн бидэнд харшлах болно” гэж Сун Зывэнийг ятгасан байна. Сталиныг яг иймэрхүү үгс хэлэхэд П.Гэндэн, Амар нарын түүний үгийг хүлээнгүйгээр дагахгүй, өөрийн өнгө аястай, тусгаар тогтнол хэмээн цээж дэлдсэн байдал ч зарим талаар нөлөөлсөн байх хэмээн санана. Яг иймэрхүү байдлаар Сталин хэд хэдэн удаагийн уулзалт дээр Хятадын Суныг ятгаж, шаардаж байж сая Гадаад Монголын статусквог хятадаар хүлээн зөвшөөрүүлж чадсан юм. Энэ бол Монголчуудын хувьд том завшаан, алхам болсоныг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй хэмээн үзэж байна. 1945 онд Японы эсрэг БНМАУ дайн зарлахдаа Өвөр Монголыг нэгтгэх тухай уриалга гаргаж, өвөр монголчуудын сэтгэлийг хоёрдуулсан нь үнэндээ Сталины дээр хэлсэнчлэн Хятадуудад “харав уу Монголчууд ингэж чадах улс хэмээхийг” үзүүлсэн хэрэг юм. Түүнээс бус Чойбалсан санаачлан Өвөр Монголыг нэгтгэх санал гаргасан хэрэг хараахан бус буй за. Өөрөөр хэлбэл Гадаад Монголын статусквог хадгалахын тулд Хятадуудад ойлгуулах олон арга хэрэглэсний нэгэн нь энэ болой.

Ишлэл зүүлт

1. Н.Магсаржав Монгол улсын шинэ түүх.,УБ., 1994он.х.22
2. Үндэсний төв архив ф.А4, т.1, х.н.656
3. Сборник дипломатических документов по Монгольскому вопросу 23 авг.1912 – 2 ноября 1913 г. Санкт петербург, 1914, с.32
4. Үндэсний төв архив. Ф.А4, д.1, х.н.39
5. Монголын ард түмний 1911оны үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцэл (1900-1914), Баримт бичгийн эмхтгэл. УБ.,1982 он эмхтгэсэн А.Очир, Г.Пүрэвээ, 178 дахь тал
6. Известия МИД России кн.5, 1915, с.76
7. Хятад, Орос, Монгол гурван улсын 1915 оны Хиагтын гэрээ Өдөр тутмын тэмдэглэл, Баримт бичгийн эмхтгэл, эмхтгэж, тайлбар бичсэн О.Батсайхан УБ., 1999 он, 577 дахь тал
8. Дурьдсан зохиол. 308 дэх тал
9. Международные отношения..., сер. 2, т.18., часть 1., с. 227
10. Үндэсний төв архив. Ф. А-2, Д.-1, Х.Н.-14, 11-14 дэх тал
11. Чойбалсан, Лосол, Дэмид. Монголын ардын үндэсний хувьсгалын анх үүсэж байгуулагдсан товч түүх. УБ.,1934 он. Дэд дэвтэр, х.76
12. БНМАУ-ын анхдугаар их хурал, УБ., 1984 он. х.318
13. Ургинская газета 25.06.1924., дугаар 82
14. Ардын эрх., 1924.,06.25., дугаар24
15. НТА.ф.4.,д.2,х.н.65 х. 9-10